



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мянгад сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/003/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 70432545
Ховд хот	Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
2026 он	Аудитор: С.Оюунжаргал Утас: 70432545 Цахим хаяг: Oyunjargals@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	10
3.1. Төлбөрийн акт .....	11
3.2 Зөвлөмж .....	11
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	13
5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ .....	15

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
МА	Магадалшгүй ажил
ЗХЗ	Захиалагчийн хяналтын зардал

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг  
Утас/Факс: (976)-7043-3061  
Email: khovd@audit.gov.mn

2026.03.25 № 277

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

МЯНГАД СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Б.БАТХИШИГ ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Ховд аймгийн Мянгад сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Мянгад сум нь 2025 оны байдлаар 3764 хүн амтай, 174 төрийн албан хаагчтай, 992 өрхтэй, 808 малтай өрхтэй үүнээс 744 малчин өрх, 64 мал бүхий өрх, жилийн эцсийн мал тооллогоор 246196 толгой мал тоолуулжээ.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 26 арга хэмжээний зардалд 3,642.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 2,819,8 сая төгрөгийг зарцуулснаас 1,759.4 сая төгрөгийг урсгал зардалд, 1,060.5 сая төгрөгийг ОНХС-ийн шилжих болон шинээр эхлэх хөтөлбөр арга хэмжээнд тус тус зарцуулсан байна.

Мянгад сум нь татварын болон татварын бус орлогоор нийт 686.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, орлогыг төлөвлөгөөг 532,9 сая төгрөг буюу 56.3 хувиар тасалжээ

**Бусад асуудлын хэсэг.**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан**

(мян.төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,021,146.29	1,240,047.07
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	622,609.45	520,489.33
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	183,022.58	294,742.62
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	7а, 7б	125,255.95	334,784.80
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	90,258.32	90,030.33
6	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		2,074,578.39	2,801,749.54
7	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	2,074,578.39	2,801,749.54
8	1.2.2.02 Биет хөрөнгө		2,033,988.39	2,761,459.54
9	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	40,590.0	40,290.0
10	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		3,095,724.69	4,041,796.62
11	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		1,887.38	407,146.57
12	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		1,887.38	407,146.57
13	2.1.1.03 Өглөг		1,887.38	407,146.57
14	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		3,093,837.31	3,634,650.04
15	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		3,093,837.31	3,634,650.04
16	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		561,660.06	561,660.06
17	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		2,146,466.02	2,691,298.54
18	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		385,711.23	381,691.45
19	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		3,095,724.69	4,041,796.62

**2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		4,319,016.59	3,887,010.98
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		624,677.04	668,446.07
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		532,298.5	478,260.75
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		558,290.88	510,780.51
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-25,992.38	-32,519.75
6	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		56,863.76	78,500.18

7	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		35,514.79	111,685.13
8	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	562,428.51	3,218,564.92
9	1.1.1.04.3 Тусламжийн орлого		0.0	2,178,372.92
10	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		3,131,911.04	0.0
11	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	3,493,505.06	3,346,198.24
12	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		3,493,505.06	3,346,198.24
13	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,431,608.36	3,217,129.41
14	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		784,237.7	929,583.43
15	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		97,626.28	116,920.59
16	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		515,996.67	619,326.1
17	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		880,833.44	1,186,168.76
18	1.1.2.01.1.05 Нормативт зардал		198.0	0.0
19	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		7,180.3	10,922.6
20	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал		7,915.0	11,534.7
21	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		104,648.07	20,663.57
22	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		1,032,972.91	322,009.67
23	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		61,896.7	129,068.83
24	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		825,511.53	540,812.74
25	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		50,673	0.0
26	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		-50,673	0.0
27	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		774,838.53	540,812.74

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мян.төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,817,625.87	2,941,811.61
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	624,677.04	668,446.07
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	532,298.5	478,260.75

4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-25,992.38	-32,519.75
5	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	56,863.76	78,500.18
6	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	35,514.79	111,685.13
7	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	21,153.9	18,426.4
8	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	12,098.04	90,617.95
9	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,262.85	2,640.79
10	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	61,037.79	2,273,365.55
11	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	61,037.79	94,992.63
12	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	900,513.12
13	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	1,277,859.8
14	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,131,911.04	0.0
15	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,507,345.39	1,908,684.02
16	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	2,507,345.39	1,908,684.02
17	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,445,448.69	1,779,615.19
18	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	779,919.81	946,007.53
19	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,835.9	119,934.3
20	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	593,068.06	606,631.91
21	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	23,777.41	35,740.01
22	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	553.7	359.6
23	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	10,231.6	11,128.6
24	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	7,924.1	7,794.7
25	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,955.12	29,947.88
26	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	893,182.99	22,070.65
27	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,896.7	129,068.83
28	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,310,280.49	1,033,127.6
29	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,074,015.84	1,105,097.72
30	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,074,015.84	1,105,097.72
31	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	1,074,015.84	1,105,097.72
32	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,074,015.84	-1,105,097.72

33	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	150	30,150
34	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-150	-30,150
35	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	236,114.64	-102,120.13
36	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	386,494.81	622,609.45
37	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	622,609.45	520,489.33

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мян.төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,318,998.77	2,318,998.77
2	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,318,998.77	2,318,998.77
3	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	774,838.53	774,838.53
4	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,093,837.31	3,093,837.31
5	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,093,837.31	3,093,837.31
6	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,093,837.31	3,093,837.31
7	1.7 Тайлант үеийн үр дүн	540,812.74	540,812.74
8	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,634,650.04	3,634,650.04

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

мян.төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	<b>3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	3,282,420.80	2,818,729.69
11	<b>3.1.01.1.1 Татварын орлого</b>	1,204,398.30	668,446.07
110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	449,354.30	478,260.75
1100	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	481,874.10	510,780.51
110001	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	331,374.10	394,678.15
110002	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	30,000.00	22,961.37
110003	3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	35,000.00	23,469.33
110008	3.1.01.1.1.1.1.07 Шууд бус орлого	85,500.00	69,671.65
1101	3.1.01.1.1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(32,519.80)	(32,519.75)
113	<b>3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар</b>	79,660.00	78,500.18

118	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	675,384.00	111,685.13
12	<b>3.1.01.1.2 Татварын бус орлого</b>	2,078,022.50	2,150,283.63
120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	94,605.00	46,863.53
	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	14,000.00	16,986.50
	3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	605.00	605.00
122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	705,557.70	825,560.30
122003	3.1.01.1.2.3.3 Аймаг нийслэлээс авсан татаас	705,557.70	825,560.30
123	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,277,859.80	1,277,859.80
II	<b>3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	3,642,858.00	2,948,111.79
21	<b>3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,929,022.50	1,857,484.54
210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,926,988.90	1,728,415.71
2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	959,873.90	919,887.73
2102	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	119,934.30	119,934.30
2103	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	623,723.70	604,632.00
2104	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	26,915.40	18,258.05
2105	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	683.20	359.60
2106	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	13,950.90	11,128.60
2107	3.1.01.2.1.1.7 Томилот, зочны зардал	9,564.00	7,794.70
2108	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,422.90	28,031.28
2109	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	110,920.60	18,389.45
213	<b>3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	2,033.60	<b>129,068.83</b>
2131	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,033.60	128,268.83
2132	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	2,033.60	800.00
22	<b>3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,633,835.50</b>	<b>1,060,477.25</b>
220001	3.1.01.2.2.1 Барилга байгууламж	550,286.70	514,257.60
221001	3.1.01.2.2.2 Их засвар	178,850.00	177,886.65
222001	3.1.01.2.2.3 Тоног төхөөрөмж	446,266.00	186,353.62
223001	3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө	458,432.80	181,979.38
23	<b>3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>80,000.00</b>	<b>30,150.00</b>
230001	3.1.01.2.3.1 Эргэж төлөгдөх зээл	80,000.00	30,150.00
8	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(360,437.20)	(129,382.10)
9	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	360,437.20	129,382.10
7	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	360,437.20	129,382.10
4	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	622,609.45
5	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	517,764.54

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мян.төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	74,952.82
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	74,952.82
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	74,952.82
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	74,952.82

12213	1.1.1.1.1.1.1.1	Нэмэлт санхүүжилтийн орлого	74,952.82
350013	1.1.1.1.1.1.1.1.3	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	74,702.82
350015	1.1.1.1.1.1.1.1.5	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	250.0
II	1.1.1.2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	50,415.63
21	1.1.1.2.1	УРСГАЛ ЗАРДАЛ	5,795.16
210	1.1.1.2.1.1	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,795.16
2104	1.1.1.2.1.1.4	Хангамж, бараа материалын зардал	2,113.96
2109	1.1.1.2.1.1.9	Бараа үйлчилгээний бусад зардал	3,681.20
22	1.1.1.2.2	Хөрөнгийн зардал	44,620.47
2200	1.1.1.2.2.1	Дотоод эх үүсвэрээр	44,620.47
220001	1.1.1.2.2.1.1	Барилга байгууламж	44,620.47
4	1.1.1	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	24,537.19
5	1.1	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(24,537.19)
6	1	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(24,537.19)

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 257,941.6 мянган төгрөгийн алдаа зөрчил<sup>1</sup> илэрснээс, 198,596.58 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>2</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн тайлант оны зээлийн хүү, алдангийг 4,697.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тооцон илэрхийлсэн.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн сумын төвийн 542.47 метрийн урттай цементэн хучилттай замын ТЭЗҮ, ерөнхий боловсролын сургуулийн ТЭЗҮ ажлыг зураг төсвийн авлагаар бүртгээгүй 36,800.0 мянган төгрөгийг шууд зардлаар бүртгэж тайлагнасан,
- Тайлант онд 8 төсөл арга хэмжээтэй холбоотой өр төлбөрийг бүртгэхдээ тооцооллын алдаа гарган 11,074.97 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн
- Өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх арга хэмжээнд олгосон санхүүжилтийн дүнгээр 34,370.0 мянган төгрөгөөр авлага илүү бүртгэсэн
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим төсөл арга хэмжээг хүлээж аваагүй, гүйцэтгэл дутуу байхад 111,654.0 мянган төгрөгийн олгосон санхүүжилтийг урьдчилж гарсан зардлаар бүртгээгүй

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харилцах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

<sup>2</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 22,155.0 мянган төгрөгийн шийдвэрлэгдээгүй асуудлыг 2026 оны эхний хагас жилийн тайлангаар залруулах боломжтой тул материаллаг бус гэж үзлээ.

Залруулагдаагүй 59,345.06 мянган төгрөгийн зөрчлөөс материаллаг бус 22155.0 мянган төгрөгийн материаллаг бус алдааны нөлөөллийг тооцон “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 59,345.0 мянган төгрөгийн 4 зөрчил<sup>3</sup> илэрснээс, 1,198.2 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт 58,146.78 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

### 3.1. Төлбөрийн акт

**3.1.1 Илрүүлэлт:** Малчдад сургалт сурталчилгаа хийх зориулалтаар ИТХ-ын ажилтны дансаар мөнгө шилжүүлэн авч зарцуулснаас 1,198.2 мянган төгрөгийн ажил гүйлгээг анхан шатны баримтгүй, төсвийг үр ашиггүй зарцуулсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн “6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах гэсэн хуулийн заалтууд санхүүгийн тайлангийн иж бүрэн, тасалбар болголт, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Төлбөрийн акт тогтоов.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 3.2 Зөвлөмж

#### 3.2.1 Орон нутгийн хөгжүүлэх сантай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Цагаанбулан багийн барилгын их засвар/ ЗХЗ-339,024/ , Гахайт багийн төвийн өргөтгөл/ ЗХЗ-867,520, норм-78077, МА-867,520/ , Сумын төвийн авто машины зогсоолын өргөтгөл/ЗХЗ-1307,884, норм-117,710, МА-1,307,884/ , Соёл амралтын хүрээлэн/ЗХЗ-1,04,974, норм-94,228, МА-1,046,974/ зэрэг төсөл арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо нийт 6,026,827 төгрөгийн нормчлолын сан, захиалагчийн хяналтын зардал, магадалшгүй ажлыг суутгаагүй нь Төсвийн тухай хуулийн 14.2.3-д өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтууд, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Нормчлолын сан, захиалагчийн хяналтын зардал, магадалшгүй ажлыг суутгаагүй зөрчлийг арилгаж барьцаа 5 хувийн санхүүжилтээс суутгаж авах.

#### 3.2.2 Орон нутгийн хөгжүүлэх сантай холбоотой асуудал

<sup>3</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Илрүүлэлт:** Цагдаагийн хэсэгт авто машин худалдан авах, Хилийн цэсийн самбар байршуулах ажлуудыг данс бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-д “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”; 18.1.Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, гэсэн заалт, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Цагдаагийн хэсгийн авто машин, хилийн цэсийн самбаруудыг холбогдох байгууллагын хөрөнгийн бүртгэлд тусгаж ажиллах

### **3.2.3 Орон нутгийн хөгжүүлэх сантай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Урьд оны үлдэгдлээс санхүүжиж байгаа бүрэн хэрэгжүүлж дуусгаагүй 3 төсөл арга хэмжээнд хяналт тавиагүй , гэрээ цуцлах, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх зэрэг арга хэмжээ аваагүй, төсвийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлж ажиллаагүй нь Төсвийн тухай хуулийн 14.2.3.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах; 16.5.4.төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх гэсэн заалт нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж** Урьд оны үлдэгдлээс санхүүжиж байгаа хэрэгжиж дуусаагүй ЕБС-ийн хашаа шинэчлэх, гудамжны эхний явган хүний зам шинээр хийх, Баянбулаг багт мал угаалгын ванн барих ажлуудад хяналт хэрэгжүүлэн хариу арга хэмжээ авч хэрэгжүүлж төсвийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мян.төгрөгөөр)

Байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
Мянгад сумын СХС	Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн тайлант оны зээлийн хүү, алдангийг зөрүүтэй тооцон илэрхийлсэн	1	4,697.6			1	4,697.6	1	4,697.60				
Мянгад сумын ОНХС	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТЭЗҮ, зургийн үнийг авлагаар бүртгэж тайлагнаагүй, шууд зардлаар бүртгэсэн	1	36,800.0			1	36,800.0	1	36,800.00				
	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим төсөл арга хэмжээг хүлээж аваагүй, гүйцэтгэл дутуу байхад олгосон санхүүжилтийг урьдчилж гарсан зардлаар бүртгээгүй	1	111,654.0			1	111,654.0	1	111,654.00				
	Тайлант онд 8 төсөл арга хэмжээтэй холбоотой өр төлбөрийг бүртгэхдээ тооцооллын алдаа гарган илүү бүртгэсэн	1	11,075.0			1	11,075.0	1	11,075.0				
	Өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх арга хэмжээнд олгосон санхүүжилтийн дүнгээр авлага илүү бүртгэсэн	1	34,370.0			1	34,370.0	1	34,370.0				

<b>Нийт дүн</b>	<b>5</b>	198,596.6			<b>5</b>	198,596.6	<b>5</b>	198,596.6				
-----------------	----------	-----------	--	--	----------	-----------	----------	-----------	--	--	--	--

#### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мян.төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Орон нутгийн хөгжлийн сан	Нормчлолын сан, захиалагчийн хяналтын зардал, магадалшгүй ажлын зардал суутгаагүй	1	6026.83					1	6026.83		
	Анхан шатны баримтгүй төсвийг үр ашиггүй зарцуулсан	1	1,198.23	1	1,198.23						
	Цагдаагийн хэсэгт авто машин худалдан авах, Хилийн цэсийн самбар байршуулах ажлуудыг данс бүртгэлд тусгаагүй	1	29,965.0					1	29,965.0		
	Он дамжсан бүрэн хэрэгжүүлж дуусгаагүй ажилд арга хэмжээ авч ажиллаагүй төсвийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлээгүй	1	22,155.0					1	22,155.0		
	<b>ДҮН</b>	<b>4</b>	<b>59,345.06</b>	<b>1</b>	<b>1,198.23</b>			<b>3</b>	<b>58,146.83</b>		

### 5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТТЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			

[Type here]